

2012 онд «террорын ажиллагаа тогтонги байсан» гэж шинжээчид үзэж байна. Хэт даврагч байгууллагуудын идэвхтэй вйл ажиллагаа ерийн хэмжээнээс хэтрээгвй. Байдлыг хяналтдаа авсан гэж янз бүрийн орны тусгай албад мэдэгдэж байна. Зовхон Сири улсын байдал оор байна. Тус улсад энгийн иргэдийн эсрэг террорын ажиллагаа бараг ерийн үзэгдэл болсон юм. Гэвч орнодийнхон эдгээр ажиллагааг санаатайгаар тоомсорлохгвй байна.

Оноодор дэлхийд хэдэн зуун судалгааг терроризмын асуудалд зориулжээ. Гэвч шинжээчид мон үзэгдлийн иж бүрэн тодорхойлолтыг оноо болтол зохиогвй байна. Терроризмын эсрэг чухам ямар арга ажиллагаа үр бүтээлтэй байгаа асуудлаар ч санал зорож байна. Одоогоор террористуудын гол зорилго энгийн номхон оршин суугчдыг мэгдэн сандрахад хүргэж, толовшсэн системийг эвдэн сүйтгэхэд оршино гэж «Оросын дуу хоолой» радиогийн асуултад хариулсан олонхи шинжээч үзэж байна. Стратегийн үнэлгээний хүрээлэнгийн захирал Александр Коновалов мон саналыг дэмжин хэлэхдээ «Дайны шинэ хэлбэрийн талаар огүүлж болно. Эдгээр хэлбэр иргэд сандарч, тороос оорсдийг нь хамгаална гэдэгт үл итгэхэд хүргэж, эдийн засгийн хэлхээ холбоог эвдэж, зах зээлийн үйлдвэрлэл эрхлэлтийн систем, ардчилсан үнэ цэнэт зүйлд цохилт огохэд чиглэгдсэн юм. Биеэ хамгаалах торолхи авьяасгвй зэрлэг этгээдүүд хогжингвй соёл иргэншлийг дайрвал амжилт гаргаж мэднэ» гэлээ.

Сүүлийн үед олон улсын терроризм оорчлогдож эхлэснийг үүний хамт шинжээчид тэмдэглэж байна. Энэ хувирал араб дахины хувьсгалтай холбоотой. Урьд энгийн номхон иргэдийн эсрэг цэргийн ажиллагаа явуулахаас буцахгвй байсан радикал хүчин оноогийн дэглэмүүдийг эсэргүүцэж эхлэв. Одоо засгийн эрхэнд гарахыг тэд улайран оролдож байна. Радикал хүчин нааштай хотолбортэй эсвэл урьдын адил эвдэн сүйтгэх зорилготой байгаа нь одоогоор тодроогвй байна. Террористууд бүр мөсөн оорчлогдох жишээ дэлхийн түүхэнд гарсан гэж цэргийн шинжээч Павел Фельгенгауэр дурдаад «Терроризм бол улс торийн тэмцлийн арга барил юм. Засгийн эрхэнд гарсан террористууд улс торч болж хувирдаг тохиолдол гарсан. Жишээ нь Ирландид террорист байсан этгээдүүд Ирландийн бүгд найрамдах намын хүрээнд терророос холдож, улс торчид болсон. Одоо тэд парламентад ажиллаж байна» гэлээ.

Гэвч эрх чөлөөний толоо тэмцэгчид хэмээн оорсдийгоо зарласан Ойрхи Дорнодын террористууд жинхэнэ улс торчид болж хувирах баталгаа алга. Эдүгээ Орос улс Сирид террорын ажиллагаа явуулж байгаа террористуудыг эрх баригч дэглэмийн статустай болгохыг саатуулж байна гэж Геополитикийн судлалын академийн еронхийлогч Леонид Ивашов үзэж байна. Энэ нь ливийн хувьсгал гэгчийг дэмжсэн АНУ-ын элчин сайдыг хоноосон ливийн «эрх чөлөө» гэгчийн хувилбарлыг Сири улсад давтуулахаас сэрэмжилж мэднэ.